



**ТОГТВОРТОЙ
УУЛ УУРХАЙН
ТӨЛӨӨ**



МОНГОЛЫН УУЛ УУРХАЙН
ҮНДЭСНИЙ АССОЦИАЦИ

**СТАНДАРТЫН
ҮНЭЛГЭЭНИЙ ПРОТОКОЛ**



НЭГ. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫН ХАМГААЛЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ГҮЙЦЭТГЭЛ, ТҮҮНИЙ ҮНЭЛГЭЭНИЙ АРГАЧЛАЛ

1.1. Зорилго

Энэхүү үнэлгээний протоколын зорилго нь уул уурхайн төсөл хэрэгжүүлэгч нарт зориулсан Тогтвортой уул уурхайн төлөө (цаашид ТУУТ гэж явах) стандартын үзүүлэлтүүдийн дагуу биологийн олон янз байдлын хамгааллын менежментийн үнэлгээг хийхэд шаардлагатай заавар, чиглэл өгөх явдал юм. Мөн тус үнэлгээний протокол нь ТУУТ стандартын хүрээнд биологийн олон янз байдлын хамгааллын менежментийн талаарх ерөнхий хүлээлтийг тусгасан бөгөөд уул уурхайн төсөл хэрэгжүүлэгчдэд биологийн олон янз байдлыг хамгаалах менежментийн зорилгыг хэрэгжүүлэхэд дэмжлэг болох юм.

ТУУТ стандартын үнэлгээний хувьд бусад менежментийн тогтолцоонд хийгдэж буй ямар ч үнэлгээний нэгэн адил системийн үзүүлэлтийн хэрэгжилт, менежментийн үйл явцын чанар, үйл ажиллагааг үнэлэхэд мэргэжлийн дүн шинжилгээ хийх тул тус протоколыг ашиглахын тулд аудит болон системийн үнэлгээний талаарх мэдлэг, биологийн олон янз байдлын менежментийн арга ажиллагаа, үүнд хамаарах зохицуулалтууд, тавигдах шаардлагуудын талаарх мэдлэг, туршлага шаардлагатай.

Энэхүү үнэлгээний протокол нь ТУУТ стандартын хүрээнд биологийн олон янз байдлын менежментийн хэрэгжилтийн түвшний үзүүлэлтүүдийг тусгасан боловч протокол нь дангаараа биологийн олон янз байдлын менежментийн үйл ажиллагааны үр дүнтэй байдлын баталгаа болохгүй.

1.2. Гүйцэтгэлийн үзүүлэлтүүд

Өөрийн зорилгод хүрэх гүйцэтгэл, зорилгыг хангахад гарч буй ахиц дэвшлийг үнэлэхийн тулд биологийн олон янз байдлын хамгааллын менежментийн протокол нь доорх гурван үзүүлэлтэд хамаарах шалгууруудыг тусгасан байдаг. Үүнд: Компанийн удирдлагын түвшинд биологийн олон янз байдлыг хамгаалах зорилго дэвшүүлж, үүрэг амлалт авч, эргэх хариуцлага, мэдээлэл харилцаатай байх;

1. Уурхайн түвшний биологийн олон янз байдлын хамгааллын төлөвлөлт, хэрэгжилт;
2. Биологийн олон янз байдлын хамгааллын менежментийн тайлагнал.

ХОЁР. ҮЗҮҮЛЭЛТҮҮД

2.1. Үзүүлэлт 1: Компанийн удирдлагын түвшинд биологийн олон янз байдлыг хамгаалах зорилго дэвшүүлж, үүрэг амлалт авч, эргэх хариуцлага, мэдээлэл харилцаатай байх

2.1.1. Зорилго

Компанийн түвшинд биологийн олон янз байдлыг хамгаалах зорилготой, хариуцах эзэнтэй, холбогдох ажилтнуудад мэдээлэлдэг байхыг баталгаажуулах.

2.1.2. Үнэлгээний шалгуур:

Түвшин	Шалгуур
С	Компани нь В түвшний бүх шалгуурыг хангаагүй.
В	- Удирдлагын зүгээс биологийн олон янз байдлыг хамгаалахаар үүрэг амлалт авсан ч энэ нь ТУУТ стандартын биологийн олон янз байдлыг хамгаалах менежментийн хүрээний зорилгуудад нийцээгүй байх. - А түвшний гүйцэтгэлийг хангах төлөвлөгөөтэй байх.
А	- Удирдлагын зүгээс ТУУТ стандартын биологийн олон янз байдлыг хамгаалах менежментийн хүрээний зорилгуудад нийцүүлэн, үр дүн гаргах зорилгоор нөлөөллийг бууруулах эрэмбээр биологийн олон янз байдлыг хамгаалахаар тодорхой үүрэг амлалт авсан болохоо илтгэн харуулсан байх. - Биологийн олон янз байдлыг хамгаалах үүрэг амлалтуудыг холбогдох ажилтнууд, гэрээт гүйцэтгэгч болон уурхайн түвшний Сонирхогчталуудын бүлэгтэргэн мэдээлдэг, харилцаа холбоотой байх, Үүрэг, амлалтуудыг хэрэгжүүлэх албан тушаалтан, түүний ажлын чиг үүрэг болон эргэн тайлагнах процесс нь тодорхой байх бөгөөд хэрэгжилтийг дэмжих шаардлагатай нөөц хөрөнгийг хуваарилсан байх.
АА	Биологийн олон янз байдлыг хамгаалах үүрэг амлалтуудын хэрэгжилт нь хараат бус баталгаажуулалт/ хяналтад (дотоод болон хөндлөнгийн) хамрагдсан байх.
ААА	Биологийн олон янз байдлыг хамгаалах үүрэг, амлалтууд нь бүрэн хэрэгжих (net zero loss) боломжтой байхаар тодорхойлсон зорилттой, зорилтоо хэрэгжүүлэх албан тушаалтан, чиг үүрэг, хариуцлага болон нөөц эх үүсвэрийг бий болгон хуваарилсан байх бөгөөд тус чиглэлээр бусад байгууллагуудтай идэвхтэй хамтран ажилладаг байх.

Түгээмэл асуултууд: Биологийн олон янз байдлын хамгааллын менежментийн чиглэлээр тухайн компанийн түвшинд тодорхойлсон үүрэг амлалт, эргэх хариуцлага, мэдээлэл харилцаа

#	Түгээмэл асуултууд
1	Биологийн олон янз байдлыг хамгаалах талаар жишиг болох хамгийн сайн баримт бичиг юу вэ?
2	Биологийн олон янз байдлыг хамгаалах бодлого нь бие даасан тусдаа баримт бичиг байх шаардлагатай юу?
3	Биологийн олон янз байдлыг хамгаалах ажлыг компанийн бизнес төлөвлөлттэй хэрхэн уялдуулан нэгтгэх вэ?
4	Үзүүлэлт 1 AAA түвшний Бүрэн хэрэгжих боломжтой байх (No Net Loss) үүрэг хариуцлага нь одоо хэрэгжиж буй төсөлд хамаарах уу ?
10	Уурхайн шатан дахь үүрэг амлалтыг илтгэн харуулах зорилгоор компанийн дотоод баримт бичгийг ашиглаж болох уу? Can corporate documentation be used to demonstrate facility-level commitment?
13	Бүрэн хэрэгжих боломжтой байх (No Net Loss) зорилтыг уурхайн үйл ажиллагааны мөчлөгийн хүрээнд хэрхэн харгалзан үзэх вэ?
14	“Хамгаалал” хэмээх үгийг хэрхэн тайлбарлах вэ?
15	“Ахлах удирдлагыг” хэрхэн тодорхойлох вэ?
16	Бууруулах эрэмбэ гэж юу вэ? (mitigation hierarchy)

Үзүүлэлт 2: Уурхайн түвшний биологийн олон янз байдлын хамгааллын төлөвлөлт БА хэрэгжилт

Зорилго

Биологийн олон янз байдлын хамгааллын үндсэн чухал хэсгүүдийг удирдахын тулд уурхайн түвшинд үр дүнтэй менежментийн систем, төлөвлөлт, хэрэгжиж буйг баталгаажуулах.

Үнэлгээний шалгуур:

Түвшин	Шалгуур
С	Компани нь В түвшний бүх шалгуурыг хангаагүй.
В	- Уурхайн түвшний биологийн олон янз байдлыг хамгаалах менежментийн төлөвлөгөөнд доорх асуудлуудыг тусгасан байх: - Уурхайн түвшний суурь өгөгдлийн үнэлгээ, боломжтой бол орон нутгийн экологийн талаарх мэдээллийг тусгасан байх. - Уурхайн түвшний биологийн олон янз байдлын мониторинг. - Биологийн олон янз байдлын дотроос тодорхойлсон онцгой ач холбогдол бүхий чиглэлүүдийн тодорхойлолт. - Голлох сонирхогч талуудын тодорхойлолт. - Төлөвлөгөөг уурхайн түвшний ахлах удирдлага батлан хэрэгжилтийг хангаж байх.
А	- Онцгой ач холбогдол бүхий биологийн олон янз байдлыг хамгаалах менежментийн систем, төлөвлөлт хэрэгждэг байх бөгөөд төлөвлөлтөд хамгийн багадаа доорх асуудлуудыг багтаасан байна: - Биологийн олон янз байдалд үзүүлэх боломжит нөлөөлөл/ эрсдэлийг үнэлэх. - Биологийн олон янз байдлын онцгой ач холбогдол бүхий асуудалд зориулсан тусгайлсан зорилтуудыг тодорхойлсон байх - Биологийн олон янз байдлыг хамгаалах тодорхой зорилтууд дэвшүүлж, үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулан, хэрэгжүүлдэг байх. - Биологийн олон янз байдлын хамгааллын менежментийн чиг үүрэг бүхий ажилтнуудыг уурхайн түвшинд томилж, үүрэг, хариуцлагажуулсан байх. - Уурхайн сургалтын хөтөлбөрт холбогдох ажилтнуудад зориулсан биологийн олон янз байдлыг хамгаалах талаар мэдлэг олгох сургалтын хөтөлбөр орсон байх. - Биологийн олон янз байдлыг хамгаалах менежментийн төлөвлөлтийг хийхдээ голлох сонирхогч талуудыг оролцуулж зөвлөлдсөн байх. Жишээ нь төр, орон нутгийн иргэд болон байгаль орчны хамгааллын байгууллагууд гэх мэт. - Уурхайн түвшинд биологийн олон янз байдлыг хамгаалах менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлж, зорилтууддаа хүрэхийн тулд гарч буй ахиц дэвшлийг байнга хянаж, ахлах удирдлагад тайлагнадаг байх.

AA	1. Уурхайн биологийн олон янз байдлыг хамгаалах менежментийг тухайн байгууллагын үндсэн бизнес төлөвлөлтийн үйл явц, арга хэрэгслүүдтэй уялдуулж нэгтгэсэн байна. Үүнд Жилийн бизнес төлөвлөлтийн үйл явц. a. Жилийн төсвийн төлөвлөлтийн үйл явц. 2. Биологийн олон янз байдлыг хамгаалах менежментийн системийн хэрэгжилтэд хараат бус баталгаажуулалт/ хяналт (дотоод болон хөндлөнгийн) хийгдсэн байх. 3. Уурхай нь биологийн олон янз байдлыг хамгаалах үйл ажиллагаанд Сонирхогч талууд болон хөндлөнгийн статус бүхий байгаль орчныг хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байгууллагуудын (орон нутгийн, бүс нутгийн болон үндэсний хэмжээний) оролцоог хангадаг байх.
AAA	1. Биологийн олон янз байдлыг хамгаалах менежмент нь өргөн хүрээний бизнесийн стратегитай (багадаа доорх зүйлсийн хоёрыг багтаасан) уялдсан байх: a. Уул уурхайн салбарын биологийн олон янз байдлыг хамгаалах талаар шинжлэх ухаан болон уламжлалт мэдлэг,ойлголтыг нэмэгдүүлэх, түүнд хувь нэмэр оруулахуйц судалгаа, хөгжүүлэлтийн үйл ажиллагаанд хөрөнгө оруулалт хийх. b. Биологийн олон янз байдлыг хамгаалах талаар шинжлэх ухааны мэдлэгийг нэмэгдүүлэхэд хувь нэмэр оруулах. c. Уул уурхайн салбарын болон бүс нутгийн хүрээнд биологийн олон янз байдлыг хамгаалах чиглэлийн зааварчилгаа, баримт бичгүүдэд хувь нэмэр оруулах. d. Уурхайн бүсээс гадуурх бүс нутгийн биологийн олон янз байдлын хамгааллыг сайжруулахад хувь нэмэр оруулах. e. Биологийн олон янз байдлыг хамгаалах чиглэлээр улс, бүс, орон нутгийн хэмжээнд хүлээн зөвшөөрөгдөх. f. Экосистемийн үйлчилгээний үнэ цэнийн үнэлгээг хийх. g. Олон нийтээс гаргасан биологийн олон янз байдлыг хамгаалах чиглэлийн үйл ажиллагаанд ажилчдын санал санаачилгууд, сайн дурын оролцоог дэмжих, урамшуулах.

Түгээмэл асуултууд: Уурхайн түвшний биологийн олон янз байдлыг хамгаалах менежментийн төлөвлөгөө ба хэрэгжилт

#	Түгээмэл асуултууд
1	Биологийн олон янз байдлыг хамгаалах талаар жишиг болох хамгийн сайн баримт бичиг юу вэ?
3	Биологийн олон янз байдлын хамгааллыг компанийн бизнес төлөвлөлттэй хэрхэн уялдуулан нэгтгэх вэ?
4	AAA түвшний Үзүүлэлт 1 дээрх бүрэн хэрэгжих боломжтой байх (No Net Loss) зорилт нь одоо хэрэгжиж буй төсөл дээр үйлчлэх үү?
5	Биологийн олон янз байдлыг хамгаалах үйл ажиллагааны төлөвлөгөө гэж юу вэ?
6	Уурхай түвшинд биологийн олон янз байдлыг хамгаалах ямар төрлийн зорилтуудыг дэвшүүлж болох вэ?
7	Суурь өгөгдөл гэж юу вэ? (Baseline data)
10	Уурхайн шатан дахь үүрэг амлалтыг илтгэн харуулах зорилгоор компанийн баримтжуулалтыг/бичиг баримтыг ашиглаж болох уу?
14	“Хамгаалал” хэмээх үгийг хэрхэн тайлбарлаж болох вэ?
15	“Ахлах удирдлагыг” хэрхэн тодорхойлох вэ?

Үзүүлэлт 3: Биологийн олон янз байдлын хамгааллын тайлагнал

Зорилго

Биологийн олон янз байдлыг хамгаалах талаар шийдвэр гаргахад мэдээлэл өгөх, гүйцэтгэлийг олон нийтэд ил тод мэдээлж байхын тулд тайлан гаргадаг эсэхийг баталгаажуулах. Биологийн олон янз байдлыг хамгаалах тайланд бодлого, мониторинг, хамгааллын санаачилгууд зэрэг элементүүд багтаж болно.

Үнэлгээний шалгуур:

Түвшин	Шалгуур
С	Компани нь В түвшний бүх шалгуурыг хангаагүй.
В	1. Байгууллагын удирдах түвшний ажилтнуудад уурхайн түвшинд биологийн олон янз байдлыг хамгаалах талаар тогтмол тайлагнадаг байх.
А	1. Биологийн олон янз байдлыг хамгаалах тайлагналддараах зүйлс багтдаг байх: а. Уурхайн биологийн олон янз байдлыг хамгаалах дотоод тайлан гарч, уурхайн түвшинд менежментийн шийдвэр гаргах үйл явцад дэмжлэг үзүүлдэг байх. б. Биологийн олон янз байдлыг хамгаалах талаар үйл ажиллагааны үр дүнг олон нийтэд тодорхой давтамжтайгаар тайлагнадаг байх.
АА	1. Олон нийтэд хандсан биологийн олон янз байдлыг хамгаалах талаарх тайлагналыг хараат бусаар баталгаажуулж эсвэл хянадаг байх (дотоод эсвэл хөндлөнгийн).
ААА	1. Биологийн олон янз байдлыг хамгаалах талаарх тайланд Сонирхогч талуудын зүгээс өгөх саналыг идэвхтэй авч, нийтэд хандан эргэн тайлагнадаг байх.

Түгээмэл асуултууд: Биологийн олон янз байдлыг хамгаалах тайлагнал

#	Түгээмэл асуултууд
1	Биологийн олон янз байдлыг хамгаалах талаар жишиг болох хамгийн сайн баримт бичиг юу вэ?
8	Биологийн олон янз байдлыг хамгаалах тайлагналыг хэрхэн хөндлөнгийн байдлаар баталгаажуулж, хянаж болох вэ (Үзүүлэлт 3)?
10	Уурхайн шатан дахь үүрэг амлалтыг илтгэн харуулах зорилгоор компанийн шатны баримтжуулалтыг/бичиг баримтыг ашиглаж болох уу?
14	“Хамгаалал” хэмээх үгийг хэрхэн тайлбарлаж болох вэ?
15	“Ахлах удирдлагыг” хэрхэн тодорхойлох вэ?

ХАВСРАЛТ 1: ТҮГЭЭМЭЛ АСУУЛТУУД

1. Биологийн олон янз байдлыг хамгаалах талаарх жишиг болох хамгийн сайн баримт бичиг юу вэ?

Олон улсын уул уурхай, металлын хорооны (ICMM) зүгээс “Уул уурхай болон биологийн олон янз байдлыг хамгаалах сайн арга ажиллагааны хөтөч” хэмээх баримт бичгийг бэлтгэн гаргасан байдаг (<https://guidance.miningwithprinciples.com/good-practice-guide-mining-biodiversity>).

2. Биологийн олон янз байдлыг хамгаалах менежментийн чиглэлээрх үүрэг амлалтууд нь ТУУТ стандартын Уул уурхай, биологийн олон янз байдлыг хамгаалах хүрээний зорилготой нийцсэн эсэхийг хэрхэн тодорхойлох вэ?

Компанийн зүгээс тодорхойлон гаргаж, хэрэгжүүлж буй биологийн олон янз байдлыг хамгаалах үүрэг амлалтын гол утга агуулга, зорилго чиглэл нь ТУУТ стандартын Уул уурхай, биологийн олон янз байдлыг хамгаалах хүрээний зорилго, чиглэлтэй нийцсэн байх ёстой. Компанийн үүрэг амлалт нь тухайн хүрээнд тогтоосон тодорхой үүргүүдийг заавал багтаасан байх шаардлагагүй ч ерөнхий байдлаар нийцэн уялдсан байвал зохино.

3. Биологийн олон янз байдлын хамгааллыг компанийн бизнес төлөвлөлттэй хэрхэн уялдуулан нэгтгэх вэ?

Уурхай нь өөрийн биологийн олон янз байдлыг хамгаалах үүрэг амлалтууд, үйл ажиллагаа нь бизнесийн үндсэн менежментийн үйл явц, арга ажиллагаатай уялдан нийцсэн гэдгийг илтгэн харуулах ёстой. Бизнес төлөвлөлтийн үндсэн үйл явц (жишээ нь жилийн бизнес төлөвлөгөө, жилийн төсөв, төслийн цар хүрээг тогтоох, дүрэм журам, баримт бичиг) нь биологийн олон янз байдлын оролцогч талуудыг тодорхойлж, төлөвлөлтийн үйл явцыг судлан хангалттай төсвийг хуваарилсан байх ёстой.

4. Цэвэр алдагдалгүй байх (No Net Loss) шаардлага одоо ажиллаж буй уурхайн үйл ажиллагаанд хамаарах уу?

Үгүй, “Цэвэр алдагдалгүй байх” үүрэг амлалт нь шинээр эхэлж буй төсөл эсвэл томоохон хэмжээний өргөтгөл хийгдэж буй төсөлд зориулагдсан. Гэхдээ одоо хэрэгжиж буй төслийн хувьд боломжтой бол өөрийн үзүүлж буй нөлөөллийг аль болох бууруулж дүйцүүлэх боломжуудыг эрэлхийлж байхыг хөхиүлэн дэмждэг.

5. “Онцгой ач холбогдол бүхий биологийн олон янз байдлын хэсэг” гэж юу вэ?

Биологийн олон янз байдлын онцгой ач холбогдол бүхий хэсэг гэж хууль, зохицуулалтын хүрээнд тавигдаж буй онцлог шаардлагуудыг тусгайлан авч үзэх, мөн биологийн олон янз байдалд учруулах боломжит нөлөөллөөс

зайлсхийх эсвэл бууруулах, нутгийн иргэд болон бусад оролцогч талуудын зүгээс илэрхийлж буй асуудлуудыг шийдвэрлэх зорилгоор уурхайн зүгээс тодорхойлон гаргасан онцгой асуудлуудыг хэлнэ. Үүний жишээнд устах аюулд орсон, нэн ховор, ховордсон төрөл зүйлс, тусгай хамгаалалттай газар нутаг, чухал ан амьтан, ургамлын суурьшил (жишээ нь зэрлэг амьтан, загас эсвэл ховордсон ургамал) эсвэл үнэ цэн бүхий экосистемийн бүрэлдэхүүн хэсэг (жишээ нь ус намгархаг газар) болон байгалийн нөөцийн ашиглалт (жишээ нь цэвэр усаар хангах) зэрэг багтаж болно.

6. Биологийн олон янз байдлыг хамгаалах үйл ажиллагааны төлөвлөгөө гэж юу вэ?

Биологийн олон янз байдлыг хамгаалах үйл ажиллагааны төлөвлөгөө нь хамгааллын зорилтуудын биелэлтийг хангахад зориулагдсан механизм юм. Бие даасан төлөвлөгөө хэлбэрээр эсвэл менежментийн системд нэгдсэн байдлаар тусгагдсан байж болно. Төлөвлөгөөнд олон тооны элементүүдийг багтаадаг ба энэ нь урьдчилан тодорхойлж гаргасан эрсдэлүүдээс хамаарна. Эрсдэлүүд нь ач холбогдол бүхий биологийн төрөл зүйлс бүхий газарт нэвтрэх хяналт, газар чөлөөлөх төлөвлөгөө, жишээ нь хөрс болон ургамал хөндөх, газар нөхөн сэргээх менежмент, газар болон зэрлэг амьтны менежментийг сайжруулах судалгаа, хөгжүүлэлтийн хөтөлбөр зэрэг олон зүйлсийг багтааж болно.

Биологийн олон янз байдлыг хамгаалах төлөвлөгөөнд дараах ажлууд багтсан байна. Үүнд:

- Суурь өгөгдлийг тусгасан байна. Үүнд уурхайн талбай, уламжлалт болон бусад орон нутгийн (оролцогч талууд) ашиглалтын бүс нутаг дахь онцгой ач холбогдол бүхий биологийн олон янз байдлын хэсгүүдийн (Түгээмэл асуулт 4) тооллого, нөхцөл байдал, түүнд үзүүлэх нөлөөлөл (ус, агаар) зэргийг багтаасан байх.
- Уул уурхайн үйл ажиллагаанаас онцгой ач холбогдол бүхий биологийн олон янз байдалд үзүүлэх боломжит нөлөөлөл ямар байхыг тодорхойлох эрсдэлийн үнэлгээний журам дүрмийг бий болгож, эрсдэлийн нөхцөл байдлыг тогтоосон (risk profile) байх.
- Эрсдэлийн нөхцөл байдалд үндэслэн хамгааллын ажлыг хэрхэн явуулах, боломжтой тохиолдолд суурь судалгаанд тусгагдсан онцгой ач холбогдол бүхий биологийн олон янз байдлын хэсгийг сайжруулах зэрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг гаргасан байх.

7. Уурхай нь биологийн олон янз байдлыг хамгаалах ямар төрлийн зорилтуудыг дэвшүүлж болох вэ?

Биологийн олон янз байдлыг хамгаалах зорилтуудад тухайн уурхайн нөхцөл байдал, байгаль орчноос хамааралтай онцлогуудыг тусгасан байна. Зорилтуудыг биологийн олон янз байдлын онц чухал хэсгүүд дээр тогтоож болох ба үйл ажиллагааны явцад тодорхой нөхцөл байдалд популяцыг хадгалан хамгаалах эсвэл тодорхой төрөл зүйлсийн суурьшлын болон/эсвэл экосистемийн нөхцөл байдлыг сайжруулах, олборлолтын дараа буцаан оруулах экосистемийн нөхцөл зэрэг дээр тодорхойлсон байж болно.

8. Суурь өгөгдөл гэж юу вэ?

Суурь өгөгдөл гэж уурхайн бүтээн байгуулалтаас өмнө тухайн орон нутгийн биологийн олон янз байдлыг үнэлэхийн тулд цуглуулсан мэдээллийг хэлнэ. Харин үйл ажиллагаа явуулж буй уурхайн хувьд суурь өгөгдөлд зэргэлдээ оршиж буй хөндөгдөөгүй усны сав газар эсвэл уурхайн орчны байгальтай ижил бусад байршлын өгөгдөл байж болох ба үүнд өмнө явагдсан уул уурхайн үйл ажиллагаа нь орон нутгийн биологийн олон янз байдлыг бүр мөсөн өөрчилсөн байж болохыг хүлээн зөвшөөрөх ёстой.

Дээрх судалгаа болон суурь өгөгдөл тухайн уурхайд байхгүй байж болох ч байгаль орчны үнэлгээнд тусгах шаардлагын учир үйл ажиллагаа явуулж буй төсөл нь суурь өгөгдлийг цуглуулах өөр бусад арга аргачлалыг сонгон ашиглаж болно. Жишээ нь уурхай тодорхой хугацаанд шалгарсан арга аргачлалыг ашиглах эсвэл ойролцоох ижил төстэй байршлын өгөгдлийг ашиглаж болох бөгөөд бусад арга аргачлалыг ч сонгон ашиглаж болох бүрэн боломжтой юм. Биологийн олон янз байдлын тайлагналыг хэрхэн хөндлөнгийн байдлаар баталгаажуулж, хянаж болох вэ (Үзүүлэлт 3)?

Баталгаажуулалт/хяналтын гол зорилго нь олон нийтэд нээлттэй тайлагнаж буй биологийн олон янз байдлын гүйцэтгэлийн үзүүлэлтүүдийн үнэн бодит, давтамж дээр төвлөрнө. Баталгаажуулалт/хяналт нь үзүүлэлтүүдийг хэрхэн тодорхойлсон болохыг харгалзахын зэрэгцээ тухайн үзүүлэлтүүдийг хамаарах хугацааны туршид зөв зохистой тодорхойлж, тайлагнаж ирснийг харуулах удирдлагын болон тайлагналын системийг мөн харгалзана. Хөндлөнгийн баталгаажуулалт/ хяналтыг гуравдагч тал хийж гүйцэтгэнэ.

9. Дотоод болон хөндлөнгийн баталгаажуулалт/хяналтын үр дүн хэдий хугацаанд хүчин төгөлдөр байх вэ?

Сүүлийн 3 жилийн хугацаанд хийгдсэн дотоод болон хөндлөнгийн баталгаажуулалт/ хяналтын үр дүн нь Биологийн олон янз байдлыг хамгаалах менежментийн үнэлгээний протоколын бүх үзүүлэлтийн АА түвшний шаардлагуудыг хангасан гэж үзнэ.

10. Уурхайн түвшний үүрэг амлалтыг батлан харуулахын тулд компанийн баримт бичгүүдийг ашиглаж болох уу?

Компанийн зүгээс бичгээр гаргасан удирдах албан тушаалтны үүрэг амлалтыг (жишээ нь компанийн бодлого хэлбэрээр) бүрэн хэрэгжүүлж, уурхайн түвшинд даган мөрдөж буйг батлах нотолгоотой тохиолдолд л уурхайн өөрийн үнэлгээ эсвэл ТУУТ стандартын хөндлөнгийн баталгаажуулалтад нотлох баримт хэмээн хүлээн авах боломжтой. Компанийн түвшний баримт бичиг болон уурхай дээрх хэрэгжилт, бодит практик нь харилцан уялдаа холбоотой байх ёстой. Хэрэв энэхүү уялдаа холбоо бий болсон бол компанийн баримт бичгийг уурхайн шатны үүрэг амлалт, үйл ажиллагаа хэмээн нотлох баримтаар авах боломжтой.

11. Бүс нутгийн биологийн олон янз байдлыг хамгаалах арга аргачлал, чиг хандлагыг үнэлгээнд хэрхэн тусгах вэ?

Нэг экосистемд хэд хэдэн тооны уурхай/ байгууламж үйл ажиллагаа явуулж буй бол компани нь биологийн олон янз байдлын хамгаалалд бүс нутгийн онцлогийг харгалзан нэгдсэн арга аргачлалыг баримтлахаар сонгож болно. Энэ нь олон компаниудын хамтын ажиллагааг мөн багтаана. Энэ тохиолдолд уурхайн түвшний ажилтнууд хоорондын үүрэг ролийг хуваах талаар сайтар ойлгож, үүнийг баримтжуулж, хамаарах түвшинд дэмжих тогтолцоог бүрдүүлэн, хэрэгжүүлдэг байх нь зүйтэй. ТУУТ стандартын үнэлгээ нь тухайн бүс нутагт буй уурхай нэг бүрийн гүйцэтгэлд үнэлгээ хийхдээ уурхайн түвшний болон бүс нутгийн тогтолцоог зэрэг харгалзан үзнэ.

12. Цэвэр алдагдалгүй байх (No Net Loss) шаардлагыг уурхайн үйл ажиллагааны мөчлөгийн хүрээнд хэрхэн харгалзан үзэх вэ?

Цэвэр алдагдалгүй байх гэсэн зорилтыг дэвшүүлсэн уурхай нь энэхүү зорилтоо уурхайн үйл ажиллагааны бүхий л мөчлөгт хамруулан авч үзэх тул үйл ажиллагааны аль нэг цэгийг харгалзан дэвшүүлж болохгүй. Учир нь тодорхой нэг шатанд биологийн олон янз байдлын асуудал нь урьдчилан сэргийлсэн, бууруулсан, багасгасан болон дүйцүүлсэн нийт дүнгээс хэтрэх явдал тохиодог болохыг санах нь зүйтэй. Уурхай нь өөрийн биологийн олон янз байдлыг хамгаалах үйл ажиллагааны төлөвлөгөөнд урт хугацаанд биологийн олон янз байдалд сөрөг нөлөө үзүүлэх өндөр эрсдэл бүхий нөлөөллийг бууруулах арга хэмжээг харгалзан үзэх нь зүйтэй. Жишээ нь эрсдэлийг бууруулахад хэт өндөр нөөц шаардахуйц, зөв зохистой шийдэх боломжгүй зарим нөлөөлөлд дүйцүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлж болно. Цэвэр алдагдалгүй байх тооцоололд нөхөн сэргээлт, хаалтын төлөвлөлт, экосистемийг сэргээх үйл ажиллагаануудыг харгалзан үзэх нь зүйтэй. Ингэснээр өмнө нь сөрөг нөлөөлөлд өртсөн газарт биологийн олон янз байдлын үнэ цэнийг буцаан нөхөн сэргээх боломжтой болно.

Үндсэн нэр томъёоны тайлбар

13. “Хамгаалал” хэмээх үгийг хэрхэн тодорхойлох вэ?

Хамгаалал гэдэг нь тодорхой газар нутгийн байгаль орчны чанар, нөөцийг хадгалах болон тус бүс нутагт орших биологийн олон төрөл зүйлс хоорондын зохистой тэнцлийг хадгалах, хамгаалахад чиглэсэн үйл ажиллагаа юм.” Тухайн нөөц нь биет (жишээ нь хатуу түлш), биологийн (халуун орны ой) эсвэл соёлын (эртний хөшөө дурсгал) хэлбэрээр байж болно. Орчин үеийн шинжлэх ухааны хэрэглээнд хамгаалал гэж нийгэм, эдийн засгийн асуудлуудын хүрээнд биологийн олон янз байдлын хамгааллын менежментийг хийж биологийн олон янз байдлыг бууруулалгүйгээр хүний хэрэгцээнд зориулсан бараа, үйлчилгээг үйлдвэрлэх үйл явцыг илэрхийлэх бөгөөд биологийн олон янз байдлын байгалийн динамик шинжийг хадгалах гэсэн утгыг агуулна.

Энэ нь хамгааллын хандлага болох “амьдралын систем болон хүн төрөлхтний шаардлагуудыг хангахдаа байгалийн өөрчлөлтгүйгээр төрөл зүйлс, газар нутгийг хамгаалах ёстой” гэсэн хандлагатай зөрчилддөг.

(Source: Michael Allaby, The Concise Oxford Dictionary of Ecology [Oxford: Oxford University Press, 1994], 92.)

14. “Ахлах удирдлагыг” хэрхэн тодорхойлдог вэ?

Биологийн олон янз байдлыг хамгаалах бодлогын хүрээнд ахлах удирдлага гэж компанийн дээд түвшний удирдлагыг (Гүйцэтгэх захирал болон/эсвэл ТУЗ) хэлнэ. Менежментийн гүйцэтгэлийн хэмжүүрийн хувьд ахлах удирдлага гэж биологийн олон янз байдлын менежментийг нийтлэг чиг үүргийг хүлээсэн компанийн болон/эсвэл уурхайн түвшний ахлах удирдлагыг ойлгоно.

15. Бууруулах эрэмбэ гэж юу вэ? (mitigation hierarchy)

Бууруулах эрэмбэ нь төслийн зүгээс биологийн олон янз байдалд үзүүлж буй сөрөг нөлөөллийг төслийн нийт хугацааны туршид бууруулахуйц чухал ач холбогдол бүхий, шат дараалсан алхмууд дээр суурилна. Үүнд дараах алхмууд багтана:

1. **Зайлсхийх** – Эрсдэл үүсгэж болохуйц нөлөөлөл бий болохоос урьдчилан сэргийлэх арга хэмжээ
2. **Багасгах** – Бүрэн хэмжээгээр зайлсхийх боломжгүй нөлөөллийн үргэлжлэх хугацаа, эрчим болон цар хүрээг бууруулах зорилгоор авч хэрэгжүүлэх арга хэмжээ
3. **Нөхөн сэргээх, унаган төрхөд нь оруулах** – Нөлөөлөлд өртөж доройтсон, хөндөгдсөн, бүрэн хэмжээгээр зайлсхийх эсвэл нөлөөллийг нь багасгах боломжгүй хөндсөн экосистемийг сайжруулах, сэргээх арга хэмжээ
4. **Дүйцүүлэх** – Бууруулах эрэмбийн өмнөх (Зайлсхийх, багасгах, нөхөн сэргээх) бүхий л шатыг хэрэгжүүлсний дараа үлдэгдэл, сөрөг нөлөөллийг дүйцүүлэн нөхөн сэргээх арга хэмжээ.

Бууруулах эрэмбийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг Олон улсын уул уурхай, металлын зөвлөлөөс гаргасан Бууруулах эрэмбийг хэрэгжүүлэх салбар хоорондын хөтөч хэмээх баримт бичгээс дараах холбоосоор үзнэ үү: <https://www.icmm.com/en-gb/publications/biodiversity/a-cross-sector-guide-for-implementing-the-mitigation-hierarchy>.

ХАВСРАЛТ 2: ТУУТ СТАНДАРТЫН ӨӨРИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ШАЛГАХ ХУУДАС

Биологийн олон янз байдлыг хамгаалах менежмент

Уурхайн нэр:		Компанийн нэр:	
Үнэлгээ хийсэн ажилтны нэр:		Хүргүүлсэн огноо:	

Дэмжих баримт бичиг / Нотолгоо:	
Баримт бичгийн нэр	Байршил

Ярилцлагад хамрагдсан хүмүүс:			
Нэр	Нэр	Нэр	Нэр

	АСУУЛТ	Т	Ү	НА	ТАЙЛБАР ба НОТОЛГОО
ҮЗҮҮЛЭЛТ 1: Компанийн удирдлагын түвшинд биологийн олон янз байдлыг хамгаалах зорилго дэвшүүлж, үүрэг амлалт авч, эргэх хариуцлага, мэдээлэл харилцаатай байх					
Үзүүлэлт 1 В түвшин	1. Удирдах түвшний ажилтны зүгээс биологийн олон янз байдлыг хамгаалахаар тодорхойлсон үүрэг амлалт авсан байна уу? Энэ нь ТУУТ стандартын Уул уурхай, биологийн олон янз байдлыг хамгаалах хүрээний зорилгуудтай нийцсэн эсвэл нийцээгүй байна уу?				
	2. А түвшний гүйцэтгэлийг хангах төлөвлөгөө байна уу?				
	Хэрэв В түвшний бүх асуултад “Тийм” гэсэн хариулт өгсөн бол А түвшний асуулт руу үргэлжлүүлэн шилжинэ. Хэрэв В түвшний бүх асуултад “Тийм” гэсэн хариулт өгөөгүй бол уурхайн гүйцэтгэлийг С түвшинд хэмээн үнэлнэ.				
Үзүүлэлт 1 АА түвшин	1. Удирдах түвшний ажилтны зүгээс ТУУТ стандартын биологийн олон янз байдлыг хамгаалах хүрээний зорилгуудад нийцүүлэн, үр дүн гаргах зорилгоор нөлөөллийг бууруулах эрэмбийн шатлалд нийцүүлэн биологийн олон янз байдлыг хамгаалахаар тодорхойлсон үүрэг амлалт авсан болохоо илтгэн харуулж байна уу?				
	2. Биологийн олон янз байдлыг хамгаалах үүрэг амлалтуудыг холбогдох ажилтнууд, гэрээт гүйцэтгэгч болон уурхайн түвшний Сонирхогч талуудын бүлэгт мэдээлж, харилцдаг уу?				
	3. Үүрэг амлалтуудыг биелүүлэх албан тушаалтан, чиг үүрэг болон эргэн тайлагнах үүрэг нь тодорхой, хэрэгжилтэд шаардлагатайнөөц хөрөнгийг хуваарилсан уу?				
	Хэрэв А түвшний бүх асуултад “Тийм” гэсэн хариулт өгсөн бол АА түвшний асуулт руу үргэлжлүүлэн шилжинэ. Хэрэв А түвшний бүх асуултад “Тийм” гэсэн хариулт өгөөгүй бол уурхайн гүйцэтгэлийг В түвшинд хэмээн үнэлнэ.				

Үзүүлэлт 1 АА түвшин	1. Биологийн олон янз байдлыг хамгаалах үүрэг амлалтууд болон эдгээрийн хэрэгжилт нь хараат бус баталгаажуулалт/ хяналтад (дотоод болон хөндлөнгийн) хамрагдсан уу?				
	Хэрэв АА түвшний бүх асуултад “Тийм” гэсэн хариулт өгсөн бол ААА түвшний асуулт руу үргэлжлүүлэн шилжинэ. Хэрэв АА түвшний бүх асуултад “Тийм” гэсэн хариулт өгөөгүй бол уурхайн гүйцэтгэлийг А түвшинд хэмээн үнэлнэ.				
Үзүүлэлт 1 ААА түвшин	1. Биологийн олон янз байдлыг хамгаалах үүрэг амлалтууд нь цэвэр алдагдалгүй байхаар тодорхойлсон зорилттой, биологийн олон янз байдлын хамгааллын чиглэлээрх бусад байгууллагуудтай идэвхтэй хамтран ажилладаг, энэхүү тогтоосон зорилтоо хэрэгжүүлэх албан тушаал, чиг үүрэг, хариуцлага болон нөөц эх үүсвэрийг бий болгон, хуваарилсан уу?				
	Хэрэв АА түвшний бүх асуултад “Тийм” гэсэн хариулт өгсөн бол ААА түвшний асуулт руу үргэлжлүүлэн шилжинэ. Хэрэв АА түвшний бүх асуултад “Тийм” гэсэн хариулт өгөөгүй бол уурхайн гүйцэтгэлийг А түвшинд хэмээн үнэлнэ.				
	КОМПАНИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ҮЗҮҮЛЭЛТ 2 ДЭЭРХ ҮНЭЛГЭЭ				Түвшин: _____

	АСУУЛТ	Т	Ү	НА	ТАЙЛБАР ба НОТОЛГОО
ҮЗҮҮЛЭЛТ 2: БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫН ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ, ХЭРЭГЖИЛТ					
Үзүүлэлт 2 В түвшин	1. Уурхайн түвшний биологийн олон янз байдлыг хамгаалах төлөвлөгөөг доорх асуудлыг оруулан боловсруулсан байна уу?				
	a. Уурхайн түвшний суурь өгөгдлийн үнэлгээ хийгдсэн, боломжтой бол орон нутгийн экологийн талаарх мэдээллийг тусгасан байх?				
	b. Уурхайн түвшний биологийн олон янз байдлын мониторинг хийдэг эсэх?				
	c. Онцгой ач холбогдол бүхий биологийн олон янз байдлын чиглэлүүдийг тодорхойлсон байх?				
	d. Голлох сонирхогч талуудыг тодорхойлсон байх?				
	2. Төлөвлөгөөг уурхайн удирдах албан тушаалтан батлан хэрэгжүүлж байна уу?				
	Хэрэв В түвшний бүх асуултад “Тийм” гэсэн хариулт өгсөн бол А түвшний асуулт руу үргэлжлүүлэн шилжинэ. Хэрэв В түвшний бүх асуултад “Тийм” гэсэн хариулт өгөөгүй бол уурхайн гүйцэтгэлийг С түвшинд хэмээн үнэлнэ.				

Үзүүлэлт 2 А түвшин	1. Онцгой ач холбогдол бүхий биологийн олон янз байдлыг удирдах менежментийн систем, төлөвлөгөө хэрэгждэг, бөгөөд хамгийн багадаа доорх асуудлыг багтаасан байна уу?:				
	a. Биологийн олон янз байдалд үзүүлэх боломжит нөлөөлөл/эрсдэлийг үнэлсэн үү?				
	b. онцгой ач холбогдол бүхий биологийн олон янз байдалд зориулсан тусгайлан зорилтуудыг тодорхойлсон уу?				
	c. Биологийн олон янз байдлын хамгааллын зорилтуудад тусгайлан хандсан үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан, хэрэгжүүлдэг үү?				
	d. Биологийн олон янз байдлын хамгааллын менежментийн чиг үүрэг бүхий ажилтнуудыг уурхайн түвшинд томилж, үүрэгжүүлсэн үү ?				
	e. Уурхайн сургалтын хөтөлбөрт холбогдох ажилтнуудад зориулсан биологийн олон янз байдлын хамгааллын мэдлэг олгох хөтөлбөр орсон байна уу?				
Үзүүлэлт 2 AAA түвшин	1. Биологийн олон янз байдлын хамгааллын менежмент нь өргөн хүрээний бизнесийн стратегид нэгдэн уялдсан, багадаа доорх асуудлын хоёрыг багтаасан байна уу:				

	a. Биологийн олон янз байдлыг хамгаалах, шинжлэх ухаан болон уламжлалт мэдлэгийн талаарх ойлголтыг нэмэгдүүлэх, хувь нэмэр оруулахуйц судалгаа, хөгжүүлэлтийн үйл ажиллагаанд хөрөнгө оруулалт хийсэн үү?				
	b. Биологийн олон янз байдлыг хамгаалах чиглэлээрх шинжлэх ухааны мэдлэгийг нэмэгдүүлэхэд хувь нэмэр оруулах.				
	c. Биологийн олон янз байдлын хамгааллыг дэмжих уул уурхайн салбарын эсвэл бүс нутгийн зааварчилгаа баримт бичгүүдэд өөрийн хувь нэмрийг оруулсан уу?				
	d. Уурхайгаас гадуурх бүс нутгийн биологийн олон янз байдлыг сайжруулахад хувь нэмэр оруулсан уу ?				
	e. Биологийн олон янз байдлын хамгааллын чиглэлээр үндэсний эсвэл бүс нутгийн хэмжээнд танигдаж, хүлээн зөвшөөрөгдсөн үү ?				
	f. Экосистемийн үйлчилгээний үнэ цэнийн үнэлгээг хийсэн үү ?				
	g. Орон нутгийн иргэдэд суурилсан биологийн олон янз байдлыг хамгаалах санаачилгуудад оролцох ажилтнуудын сайн дурын оролцоог дэмжин урамшуулдаг уу ?				
Хэрэв AAA түвшний бүх асуултад “Тийм” гэсэн хариулт өгсөн уурхайн гүйцэтгэлийн түвшнийг AAA гэж үнэлнэ. Хэрэв AAA түвшний бүх асуултад “Тийм” гэсэн хариулт өгөөгүй бол уурхайн гүйцэтгэлийг AA түвшинд хэмээн үнэлнэ.					
КОМПАНИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ҮЗҮҮЛЭЛТ 2 ДЭЭРХ ҮНЭЛГЭЭ					Түвшин: _____

	АСУУЛТ	Т	Ү	НА	ТАЙЛБАР ба НОТОЛГОО
ҮЗҮҮЛЭЛТ 3: БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫН ХАМГААЛЛЫН ТАЙЛАГНАЛ					
Үзүүлэлт 3 В түвшин	1. Уурхай нь удирдах албан тушаалтанд биологийн олон янз байдлын хамгааллын талаар байнга тайлагнадаг уу?				
	Хэрэв В түвшний бүх асуултад “Тийм” гэсэн хариулт өгсөн бол А түвшний асуулт руу үргэлжлүүлэн шилжинэ. Хэрэв В түвшний бүх асуултад “Тийм” гэсэн хариулт өгөөгүй бол уурхайн гүйцэтгэлийг С түвшинд хэмээн үнэлнэ.				
Үзүүлэлт 3 А түвшин	1. Биологийн олон янз байдлын хамгааллын тайлагнал хийгдэж, үүнд дараах асуудлууд багтдаг уу?				
	a. Биологийн олон янз байдлыг хамгаалах талаар дотоод тайлан гарч, уурхай дээрх менежментийн шийдвэр гаргах үйл явцад дэмжлэг үзүүлдэг үү?				
	b. Биологийн олон янз байдлыг хамгаалах талаар олон нийтэд хандан тодорхой давтамжтайгаар тайлагнадаг уу ?				
	Хэрэв А түвшний бүх асуултад “Тийм” гэсэн хариулт өгсөн бол АА түвшний асуулт руу үргэлжлүүлэн шилжинэ. Хэрэв А түвшний бүх асуултад “Тийм” гэсэн хариулт өгөөгүй бол уурхайн гүйцэтгэлийг В түвшинд хэмээн үнэлнэ.				
Үзүүлэлт 3 АА түвшин	1. Олон нийтэд хандсан биологийн олон янз байдлын хамгаалах талаарх тайланг хараат бусаар баталгаажуулж эсвэл хянадаг (дотоод эсвэл хөндлөнгийн) уу?				
	Хэрэв АА түвшний бүх асуултад “Тийм” гэсэн хариулт өгсөн бол ААА түвшний асуулт руу үргэлжлүүлэн шилжинэ. Хэрэв АА түвшний бүх асуултад “Тийм” гэсэн хариулт өгөөгүй бол уурхайн гүйцэтгэлийг А түвшинд хэмээн үнэлнэ.				
Үзүүлэлт 3 ААА түвшин	1. Биологийн олон янз байдлыг хамгаалах тайланд Сонирхогч талуудын зүгээс өгөх саналыг идэвхтэй авч, нийтэд хандан эргэн тайлагнадаг уу?				
	Хэрэв ААА түвшний бүх асуултад “Тийм” гэсэн хариулт өгсөн бол уурхайн гүйцэтгэлийг ААА түвшинд үнэлнэ. Хэрэв ААА түвшний бүх асуултад “Тийм” гэсэн хариулт өгөөгүй бол уурхайн гүйцэтгэлийг АА түвшинд хэмээн үнэлнэ.				
	КОМПАНИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ҮЗҮҮЛЭЛТ 2 ДЭЭРХ ҮНЭЛГЭЭ				Түвшин: _____